

ГАРЧИГ

ГАРЧИГ.....	1-2
ХҮСНЭГТИЙНЖАГСААЛТ	3
ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	4
1.УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	5
1.1,Ерөнхий мэдээлэл.....	5
1.2, Хонгорын хайлуур жоншны ордын уул-техникийн нөхцөл.....	5
1.3, Төслийн байршил.....	6
1.4, Өрөмдлөг тэсэлгээний ажил.....	7
1.5. Дэд бүтэц объектууд.....	7
1.5.1.Уурхайн авто засварын газар ба сэлбэгийн агуулах.....	7
1.5.2. Тэсрэх материалын агуулах.....	8
1.5.3. Уурхайн үйлдвэрийн цахилгаан хангамж.....	8
1.5.4. Түлш шатах тослох материалын хангамж.....	8
1.5.5.Уурхайн удирдлага болон ажилчидын хотхоны байр.....	8
1.5.6. Зам тээвэр харилцаа холбоо.....	9
1.5.7. Хүдэр тээвэрлэх зам.....	9
2.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	9
2.1. Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт.....	10
2.2. Гадаргын ба газрын доорхи усны нөөц.....	12
2.3. Хөрсөн бүрхэвчинд учрах сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт	35
2.4. Газрын хэвлийд сөргөөр нөлөөлхөөс сэргийлэх төлөвлөгөөний биелэлт.....	38
2.5. Ургамлан бүрхэвчинд учрах сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт.....	43
2.6. Амьтаны аймагт учрах сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт.....	50
3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	54
4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	54
5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	69
6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	69
7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	72
7.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа, осолгүй ажиллах сургалт суртчилгаа тогтмол өгч ажиллах.....	72
7.2. Галын болон гамшигийн аюулаас сэргийлэх сургалт авах.....	80
7.3. Олборлолтын бүсийн хаалт хамгаалалт.....	90
7.4. Яаралтай тусламжийн эм тариа бэлэн байлгах.....	91
7.5. Ажилчидыг эрүүл мэндийн шинжилгээнд хамруулах.....	93
7.6. ХАБЭА-н зааварчилгаа тогтмол өгөх.....	96
7.7. Гамшигийн төлөвлөгөө боловсруулах.....	100

7.8. Галын дүгнэлт гаргуулах.....	100
7.9. Хөдөлмөр хамгааллын хувцасаар хангах.....	105
8.ХОГ, ХАЯГДАЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	108
8.1. Хог хаягдалын гэрээ байгуулах, сумын нэгдсэн хогийн цэгт хог хаягдал хаях.....	108
8.2. Хуванцар сав шил лааз хийх хогийн цэг байгуулах.....	111
8.3. Орон нутгийн зам дагуу цэвэрлэгээ хийх.....	112
8.4. Сумын хог цэвэрлэгээнд туслах	114
8.5. Хог хаядаггүй “Соёлтой ажилтан” аян зохион байгуулах.....	117
8.6. Аюултай хог хаягдалыг цэгт хадгалах, бүртгэл хөтлөх, эрх бүхий байгууллагад тушаах...119	
9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР, ТҮҮНИЙ ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	133
10. АЙМАГ НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ.....	147
11.УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	153
11.1. Байгаль орчны мэргэжилтэнг сургалт семнарт хамруулах,,,,,,.....	153
11.2. Байгаль орчны туслах ажилтан ажиллуулах.....	155
11.3. Уурхайн нэр хаяг бүхий самбар байршуулах.....	156
11.4. Орон нутгаас тавьсан санал хүсэлт шийдвэрлэх.....	157
12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	158
12.1. 2023 оны БОМТ батлуулах.....	158
12.2. 2023 оны БОМТ-г Айраг сумын ЗДТГ-т хүргүүлэх.....	160
12.3. 2023 оны БОМТ-ний гүйцэтгэл тайлан дүгнүүлэх.....	160
12.4. Иргэдээс ирсэн санал гомдол шийдвэрлэх.....	161
12.5. Аймаг сум багаас ирүүлсэн санал хүсэлтийн дагуу тусламж үзүүлэх.	161
ДҮГНЭЛТ.....	166
ХАВСРАЛТ.....	166

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.Төслийн техник тоног төхөөрөмжийн хүчин чадалын тойм үзүүлэлт.....	6
Хүснэгт 2. Талбайн булангийн цэгүүдийн солбилцол	7
Хүснэгт 3. Тэрбум мод хөтөлбөрийн зардлын тооцоо.....	53
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөвийн төлөвлөгөөний биелэлт.....	58
Хүснэгт 5. Нөхөн сэргээлтийн техникийн зардлын тооцоо.....	60
Хүснэгт 6. Нөхөн сэргээлтийн цалингийн зардлын тооцоо	61
Хүснэгт 7. Нөхөн сэргээлтийн бусад зардлын тооцоо	61
Хүснэгт 8. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төсвийн төлөвлөгөөний биелэлт.....	70
Хүснэгт 9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төсвийн төлөвлөгөөний биелэлт.....	73
Хүснэгт 10. Осол эрсдэлийн менежментийн төсөвийн төлөвлөгөөний биелэлт.....	108
Хүснэгт 11. Хог хаягдалын менежментийн төсөвийн төлөвлөгөөний биелэлт.....	132
Хүснэгт 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төсөвийн төлөвлөгөөний биелэлт.....	146
Хүснэгт 13. Удирдлага зохион байгуулалтын төсвийн төлөвлөгөөний биелэлт	158
Хүснэгт 14. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний төсвийн биелэлт	165
Хүснэгт 15. Байгаль орчны менежментийн төсөвийн төлөвлөгөөний биелэлт.....	167

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Зам талбай усалж буй байдал.....	10
Зураг 2. Хурдны хязгаарын тэмдэг тэмдэглэгээ.....	12
Зураг 3. Шинэ ба хуучин худаг.....	27
Зураг 4. Цэцгийн мандал бий болгосон байдал.....	35
Зураг 5. Бордоо худалдаж авсан байдал.....	37
Зураг 6. Уурхайн бүсд хориглох тэмдэг байршуулсан байдал.....	38
Зураг 7. Тээврийн зам дагуу хориглох тэмдэг байршуулсан байдал	40
Зураг 8. Тээврийн зам дагуу ХОБОМ баг тэмдэг байршуулсан байдал	43
Зураг 9 Ургамалд мониторинг хийж буй байдал.....	44
Зураг 10. Мод тарьж буй байдал.....	46
Зураг 11. Амьтны талаар мэдлэг олгох сургалт орж буй баайдал.....	50
Зураг 12. Усан санг усаар дүүргэсэн байдал	52
Зураг 13. Шинээр хийсэн усан онгоц.....	52
Зураг 14. Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт хийж эхлэх үеийн байдал.....	55
Зураг 15. Оршуулгыг хашаажуулсан байдал.....	74
Зураг 16. ХАБ, Гал, Гамшигийн сургалт авч буй байдал.....	76
Зураг 17. Олборлолтын бүсийг хашаажуулсан байдал.....	90
Зураг 18. ХАБ- н тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал	99
Зураг 19. Гал унтраах хэрэгсэлийг байршуулсан байдал.....	103
Зураг 20. Хогийн цэгт хогоо асгаж буй байдал.....	110
Зураг 21. Орон нутгийн зам дагуу цэвэрлэгээ хийж буй байдал.....	112
Зураг 22. Хог хаягдалын талаар мэдлэг олгох самбар.....	117
Зураг 23 Үлгэр жишээ ажилтан шагнах үйл ажиллагаа.....	119
Зураг 24 Аюултай хог усгуулсан.....	128
Зураг 25 Аюултай хогийн цэг байгуулсан.....	128
Зураг 26 Стандарт бие засах газар байгуулсан байдал.....	131
Зураг 27 Шинжилгээний дээж авч буй зураг /хавар/.....	137
Зураг 28 Шинжилгээний дээж авч буй зураг /намар/.....	143
Зураг 29. Зудны хүндрэлд тусалсан буй байдал.....	147
Зураг 30. БО-ны мэргэжилтэнг сургалтанд хамруулсан байдал.....	154
Зураг 31. Уурхайд хаяг байршуулсан байдал.....	156
Зураг 32. Айраг сумын 100 жилд хандив үзүүлсэн байдал.....	157
Зураг 33. Нард багийн иргэдэд өвсний тусламж үзүүлсэн байдал.....	161
Зураг 34. Нард багт халаалт шийдэж өгсөн байдал.....	164

1. УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1.Ерөнхий мэдээлэл

Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших MV-005692 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй тус орд нь “Сэнтурия монгу” ХХК-н эзэмшилт байсныг Кадастрын хэлтэсийн даргын 774 тоот шийдвэрийг үндэслэн 2018 оны 11-р сарын 07-ны өдөр “Мин Ли Да” ХХК нь өөрийн нэр дээр шилжүүлэн авсан.. Уг талбай нь үндсэндээ “Хонгор” гэж нэрлэгддэг бөгөөд 112 га талбайд 5692А ашиглалтын тусгай зөвшөөрлийг анх 2003 оны 04 сарын 28 өдөр “Өсөн”ХХК-д тухайн үеийн АМГТХЭГазрын даргын тушаалаар олгосон. Улмаар АМГТГ-ын кадастрын хэлтэсийн 2024.07.01-ны өдрийн 10/2854 тоот шийдвэрийн дагуу “Мин Ли Да” ХХК-с “Си Эм Кингс” ХХК нь өөрийн нэр дээр шилжүүлэн авсан болно.

Төслийн нэр: Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших MV-005692 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Хонгорын хайлуур жоншны орд” –ыг ил болон далд аргаар ашиглах төсөл

Төсөл хэрэгжүүлэх аж ахуй нэгж, Байгууллагын нэр “Си Эм Кингс” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9019088009

Регистрийн дугаар: 6302513

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Дорноговь аймаг, Сайншанд сум, 2-р баг, Эрх чөлөө 2 гудамж 205 байр 16 тоот Утас: 976-86862918

Төслийн зорилго: Энэхүү төслийн зорилго нь тус ордыг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар ил аргаар ашиглан олборлолт явуулахад оршино.

Төсөл хэрэгжих үе шат: MV-005692 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд 2033 он дуустал ажиллах төлөвлөгөөтэй.

1.2.Хонгорын хайлуур жоншны ордын уул-техникийн нөхцөл

Бүс нутгийн хэмжээнд говийн их мужид байрладаг. Талбайд цав толгодлог, ухаа гүвээт рельеф зонхилох бөгөөд үнэмлэхүй өндөр 1158.6-1311.8м, харьцангуй өндөр 30-50м хүрнэ.

Тус уурхайн нөөцийн хэсэглэлийн талбайд 84490 тн хүдэр үлдсэн байна. Энэ хүдрийн биет нь баруун хойноос зүүн урагш сунаж тогтсон судлын төрлийн биет байна. Хонгорын

хайлуур жоншны хүдрийн биетийн урт 240 метр, хүдрийн биетүүдийн нийлбэр зузаан 4-8 метр, гүндээ 60 метр хүртэл гүнд судлагдсан байна.

Тус ордын 2024 онд зөвхөн ил аргаар олборлолт явуулсан бөгөөд уурхайд 5ш ковш, 8ш эксковатор, 12 ш өөрөө буулгагч, 2ш бульдозер, 3ш зам усалгааны машин, 1ш ундны усны зөөврийн машин, 3ш усны зөөврийн машин бүхий үндсэн болон туслан гүйцэтгэгч байгууллагын нийт 120 хүн 2 ээлжээр ажиллав.

Хонгорын хайлуур жоншны ордод нэвтэрсэн уул өрөмдлөгийн ажлын үед 536.0м хүртэл гүнд ус агуулагч давхарга илрээгүй нь ордыг ашиглах үед ямар нэг сөрөг нөлөөгүй олборлолтын таатай нөхцөлийг бүрдүүлж байгаа юм. Ижил төрлийн бусад ордтой харьцуулбал Хонгорын хайлуур жоншны ордын ерөнхий суурь усжилт нь нийт талбайн хэмжээнд маш бага, туйлын хязгаарлагдмал учраас ордын олборлох үед уул-технологийн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хүндрэлгүй юм.

Хүснэгт 1. Төслийн техник тоног төхөөрөмжийн хүчин чадалын тойм үзүүлэлт

№	Техникийн нэр төрөл	Техникийн марк	Тоо хэмжээ /ш/	Техникийн үзүүлэлт		
				Ажлдын багтаамж, м ³ (тн)	Хурдны дээд хязгаар км/цаг	Жилийн бүтээлийн норм, мян.м ³
1	Экскаватор	Hyundai-2900LC	8	4.0-5.5	3.1	361.3
2	Автосамосвал	HOWO	6	25	59	128.3
3	Автосамосвал	North-Benz	6	21	75	
4	Утгуурт ачигч	ZL-50	5	3.0	13.4	906.6
5	Бульдозер	D-7	2	5.0	10.0	400.0

1.3.Төслийн байршил

Хонгорын хайлуур жоншны орд нь Дорноговь аймагийн Айраг сумын нутөг дэвсгэрт байрлах бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 280км, Айраг сумаас баруун хойш 27 км, Даланжаргалан сумын төвөөс баруун урагш 13км зайд оршдог. Талбайн хэмжээ: 112 гектар, Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: L-49-9

Хүснэгт 2. Талбайн булангийн цэгүүдийн солбилцол

Д/д	Өргөрөг			Уртраг		
	градус	минут	секунд	градус	минут	секунд
1	45	48	11.62	109	02	16.73
2	45	48	11.62	109	00	31.73
3	45	48	27.62	109	00	31.73
4	45	48	27.62	109	02	16.73

1.4.Өрөмдлөг тэсэлгээний ажил

Өрөмдлөг тэсэлгээний ажлыг “ФООР БЛАСТ” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэх ажиллаж байна.

Доголын талбайг өрөмдлөгт бэлтгэхдээ талбайд буй саад болох төхөөрөмж бусад зүйлийг зайлуулах, тэгшлэх, зам засах зэрэг ажлыг долдуу бульдозер хэрэглэж гүйцэтгэнэ.

Засаж бэлтгэсэн талбайд маркшейдерийн хэмжилтээр цооног байрлах тэмдэглэгээг хийх ба цахилгаан, шахсан агаар хангах өрөмдөх төхөөрөмжөө байрлуулж ажилд бэлтгэх ажиллагааг хэрэгжүүлнэ.

Өрөмдлөгийн паспортоор цооног бүрийн байршил, гүний хэмжээг тогтооно. Хяналтын хэмжилтээр ажлын хэрэгжилийг тодорхойлох ба өрөмдлөг торны зай, гүний зөрүү нь 0.3 м-с хэтрэхгүй байх ёстой. Цооног янз бүрийн учир шалтгаанаар нурж гүн нь хорогдох, цасаар дүүрэх, ус тогтох мөстөх зэрэг тохиолдолд дахин өрөмдлөг хийж засварлана. Эдгээр ажлыг багасгахын тулд өрөмдөгдсөн цооногийн шилжих нөөцийг (тэслэгдээгүй үлдэх) багасгах хэрэгтэй.

1.5 Дэд бүтэц,объектууд

Уурхайн авто засварын газар ба сэлбэгийн агуулах

Ил уурхайн уулын үндсэн техник тоног төхөөрөмжүүд болон бусад аж ахуйн хангамж үйлчилгээний техник тоног төхөөрөмжүүдийг зогсоолд байрлуулдаг. Мөн уурхайн техникүүдийг засварлах зорилгоор засварын газар/цех/ болон сэлбэг хэрэгсэлийн агуулах, авто гражуудыг уурхайн хотхоны дэргэд уурхайн хотхоноос 200 метр зайд байгуулсан. Уулын машин тоног төхөөрөмж механизмын найдвартай ажиллагааг хангах үүднээс уулын үндсэн тоног төхөөрөмжүүдийн урсгал систем, график төлөвлөгөөтэй үзлэг оношилгоо засвар үйлчилгээ явуулна.

Уурхайн авто засварын газар болон сэлбэг хэрэгсэлийн агуулах нь уурхайн техник тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор техникийн өдөр дутамын үзлэг үйлчилгээ, урсгал засвар засварын ажилд шаардлагатай аливаа материал, сэлбэг хэрэгсэл, тос тотсолгооны материал зэргийг хүлээн авах хадгалах, засаж сэлбэх, тавьж олгох зориулалттай байна. Эдгээр барилга байгууламжууд нь галд тэсвэртэй буюу шатдаггүй сэндвичэн барилга юм.

Тэсрэх материалын агуулах.

Тэсрэх материалын агуулахыг талбайд ил уурхай болон уурхайн тосгон зэрэг барилга байгууламж объектуудаас зайтай бариж байгуулан ашиглаж байна. Ингэхдээ уг агуулахыг “Ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм” болон “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм” –ийн дагуу бариж байгуулан энэхүү дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллаж байна. Тэсрэх материалын агуулахыг галд тэсвэртэй материал болох тоосго болон бетон зуурмаг зэрэг материалаар бариж байгуулсан. 2024 оны олборлолтын хугацаанд 162 тн тэсрэх бодис хэрэглэхээр төлөвлөж, үүнийг бүрэн хэрэглэж дууссан. Иймээс агуулахын багтаамж нь уурхайн нэг сарын хэрэглээг хангаж байхаар буюу 8тн багтаамжтай агуулах юм.

Уурхайн үйлдвэрийн цахилгаан хангамж

Хонгорын хайлуур жоншны уурхайн нь Даланжаргалан сумаас татсан 35КВ-н 14.3км ЦДАШ, 630 кВа-н дэд станцыг 2020 онд ашиглалтанд оруулж Чойр дахь цахилгаан шугам сүлжээний байгууллагатай гэрээ байгуулж эрчим хүчээ хангаж байна. 2025 онд Уурхайн үйл ажиллагааны цахилгаан хангамжийг 110квт болгон нэмэх шаардлагатай байгаа тул Айраг сумаас эрчим хүч татах зорилгоор “Нойкравт” ХХК-тай 2024 оны 11 сард гэрээ байгуулан ажиллаж байна.

Түлш, шатах тослох материалын хангамж

Шатах тослох материалын түр агуулах болон ШТС нь торон хашаагаар хүрээлэгдсэн задгай талбайд үйлдвэрийн цогцолбороос 100-с доошгүй метр зайд ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд байрлаж байна. 60 тонны 1 ширхэг ёмкость бүхий ШТС юм. Уурхайн түлш шатахуун, шатах тослох материалыг “Сан петриолум” ХХК-с зөөвөрлөн хангаж байна. ШТС –ыг галын аюулгүй байдлын үүднээс гал унтраах багаж хэрэгсэлээр хангаж, тэмдэг тэмдэглэгээг байршуулан тоноглогдсон болно.

Уурхайн удирлага болон ажилчидын хотхоны байр

Уурхайн захиргаа болон инженер техникийн ажилчидын ажиллах нөхцөлөөр хангах үүднээс тус талбайд уурхайн оффис 1 ширхэг байгуулсан ба үүнд уурхайн инженер техникийн ажилчид, санхүү эдийн засаг, уурхайн дарга, ажилчидад ажлын зааварчилгаа /наряд/ өгөх, гол тогоо, амрах байрнууд гэх мэт 35 өрөө тасалгаатай. Мөн туслан гүйцэтгэгч байгууллагын ажилчид байх зориулалт бүхий 1 ширхэг нэмэлт байр бариж байгаа бөгөөд 2025 онд ашиглалтанд орох төлөвлөгөөтэй байгаа юм. Төслийн эхний жилийн хүрээнд хонгорын ордын олборлолт явуулах үед ажиллах хүчний хэрэгцээнд тулгуурлан уурхайн хотхоны төлөвлөлтийг урьдчилсан байдлаар хийсэн байсан ба уурхайчдын хотхон нь нийт 30 хүний багтаамжтай байсан бол үйл ажиллагаатай уялдуулан ийнхүү өргөтгөн барилга байгууламж бариж байгаа болно.

Зам тээвэр харилцаа холбоо

Хонгорын хайлуур жоншны орд нь Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших бөгөөд сумын төвөөс баруун хойш 27 км, Даланжаргалан сумаас зүүн урагш 13 км-т Улаанбаатар хотоос 280 км-т дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн районд байрлаж байна.

Хүдэр тээвэрлэх зам

Уурхайн бүсээс Дорноговь аймгийн Айраг суманд байрлах гаалийн талбайруу хүдэрээ тээвэрлэдэг.

Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд 63.06м² талбайд модны суулгац суулган ,арчилж, тордон усалж хашаажуулан 1000ш модны суулгац суулган ургуулж байна.

2.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөхдөө зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр төлөвлөсөн.

2.1.Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний биелэлт

2.1.1. Тоосжилт бууруулах, технологийн замын усалгаа хийх төлөвлөгөөний дагуу автоцистерн маркын машинаар дулааны улиралд буюу 2024.05.23-2024.09.30 хүртэл усалгаа хийж ажиллав. Тухайн хугацаанд бороотой өдрүүд багагүй байсан тул усалгааг зөвхөн хуурайшилттай өдрүүдэд өдөр бүр 10тн усаар усалгаа хийж ажиллав.

Зураг -1 зам усалж буй байдал





Тээврийн хэрэгсэлд хурдны хязгаарлалтыг мөрдүүлэн ажиллах, хурдны хязгаарын тэмдэг тэмдэглэгээг байршуулах төлөвлөгөөний дагуу уурхайн бүс дотор болон тээврийн зам дагуу тэмдэг тэмдэглэгээ байршуулав. . Үүнд хурдны хязгаарын тэмдэг 6ш, зогсоолын тэмдэг 4, заах тэмдэг 8, анхааруулах тэмдэг 5ш

Зураг 2. Хурдны хязгаарын тэмдэг тэмдэглэгээ



2.1.2. Хүчтэй салхитай үед уурхайн уулын ажлыг хязгаарлах Хөрс хуулалт, олборлолт, тээвэрлэлтийг хязгаарлах гэж төлөвсөний дагуу 2024 оны 09 сарын 9,28 өдөрүүдэд их хэмжээний цас орж, цасан шуурга болсон учир уулын ажил зогсолт хийсэн байна.

2.2. Гадаргын ба газрын доорхи усны нөөц

2.2.1 Ус ашиглах хууль эрх зүйн бичиг баримт бүрдүүлж нийт 5.243.520 төгрөгийн төсөв зарцуулан ажиллав.

**“СИ ЭМ КИНГС” ХХК-ийн MV-005692 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛТЭЙ “ХОНГОРЫН ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД”-ЫН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2024 он

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР 2024 ОНЫ УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ**

2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар-21

Сайншанд хот

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, хаяг, утас, факс, улсын бүртгэлийн дугаар:
“Мин ли да” ХХК захирал YANG ZHENCHUN, Дорноговь аймаг, Айраг сум, 4-р баг, Цагаан
дөрвөлж, Утас: 88101993, 96643116, Улсын бүртгэлийн дугаар 9019088009, регистрийн
дугаар 6302513.

2. Төслийн нэр, байршил:

“Хонгор-Овоо” нэртэй хайлуур жоншны орд нь Айраг сумын нутаг дэвсгэрт байрлах бөгөөд
Улаанбаатар хотоос зүүн урагш 260 км, Айраг сумаас баруун хойш 26 км, Даланжаргалан
сумын төвөөс баруун урагш 13 км зайд оршдог.

3. Төсөл хэрэгжүүлэгч: “Мин ли да” ХХК

4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат /X,Y/: MY-005692

X	Y
109° 02' 16.73"	45° 48' 11.62"
109° 00' 31.73"	45° 48' 11.62"
109° 00' 31.73"	45° 48' 27.62"
109° 02' 16.73"	45° 48' 27.62"

5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт:

Хайлуур жоншны ордыг ашиглах ажил

6. Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/:

Уурхай нь хоногт 3 ээлжээр ажиллах ба ээлжийн үргэлжлэх хугацаа 8 цаг байна. Жилд 342
хоног ажиллана. Олборлолтын ажилд Хятад улсад үйлдвэрлэсэн FW 936 маркийн далд
ачигч машин, “Shen wei” маркийн тэргэнцэр ажиллана. Хээрийн ангид нийт 5-10 хүний
бүрэлдэхүүнтэй ажиллана.

7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ:

2024 онд 1496.0 м үндсэн ба бэлтгэл малталт хийж дайвар олборлолтоор 2993.1 тн хүдэр,
32775.0 м³ хоосон чулуу гаргана. Нийт 68396.0 мян.тн хүдэр олборлоно.

8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо.метрээр/:

Компаний эзэмшлийн 3 л/сек ундрагатай 1 худагтай. Унд ахуй, ногоон байгууламж, зам
талбайн усалгаанд ашигладаг.

9. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, барилга, байгууламжийн хэмжээ хийц/:

Худгийн барилгатай. 109° 02' 10.07"E, 45° 46' 51.48"N

10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /насосны хүчин чадал, марк/:

Мэдээлэл байхгүй.

11. Дамжуулах байгууламж /шугам сүлжээний урт, диаметр/:

12. Хаягдал бохир усны хэмжээ, цэвэрлэгээний арга, түвшин:
Хаягдал бохир усыг хөрсөнд шингээн зайлуулдаг.

13. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл: БОНБ-н нарийвчилсан үнэлгээний тайланг 2019 онд
“Ашид Ананда” ХХК-р хийлгэсэн.

14. Онцгой нөхцөл:

15. Холбогдох хууль, дүрэм, журам, норм, стандарт, баримт бичгийн дагуу усны
зарцуулалтыг
тооцох

Байгаль орчны сайдын 2015 оны А/301 дугаар тушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн
үйлдвэрлэхэд зарцуулах усны түр норм”-ын дагуу тооцоход

$29\text{хүн} \times 20\text{л/хон} \times 342\text{хон} = 198,3\text{м}^3$ / ажиллах нийт хугацаанд-унд ахуйн усны хэрэгцээ
 $17000,0\text{м} \times 4,0\text{м} \times 2\text{л/м}^2 \times 1\text{удаа/хон} \times 180\text{хон} = 24480,0\text{м}^3$ зам талбайн тоосжилт дарахад
ашиглах ус

$900\text{ш} \times 40\text{л} \times 48\text{удаа} = 1728,0\text{м}^3$ – ногоон байгууламжийн усалгаа

Нийт ашиглах усны хэмжээ: $198,3\text{м}^3 + 24480,0\text{м}^3 + 1728,0\text{м}^3 = 26406,3\text{м}^3$ ажиллах нийт
хугацаанд

16. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийн
хэмжээ:

Зам талбайн тоосжилт дарахад ашиглах $24480,0\text{м}^3$, ногоон байгууламжийн усалгаа $1728,0\text{м}^3$, ашиг олох зориулалтаар ашиглах $198,3\text{м}^3$ усыг газрын доорх усны төлбөрийн хэмжээг
“Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2011 оны 302
дугаар тогтоолоор Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт тогтоосон газрын
доорхи усны экологи эдийн засгийн суурь үнэлгээ, Засгийн газрын 2013 оны 327 дугаар
тогтоолоор тогтоосон ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, Засгийн газрын 2013 оны
326 дугаар тогтоолын 1-р хавсралтын 3. 9. 10-д заасан заасан усны нөөц ашигласны
төлбөрийн хэмжээг үндэслэн тооцож, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан
усны төлбөрийг “Төсвийн тухай” хуулийн 23.6.5-д заасны дагуу аймгийн Төрийн сангийн
060000-944 тоот дансанд төвлөрүүлэх;

Монгол улсын Засгийн газрын 2013 оны 326, 327 дугаар тогтоолыг үндэслэн ус ашигласны
төлбөрийг тооцвол:

1м^3 усны нөөц ашигласны төлбөр: $3700\text{төг/м}^3 \times 0,20 \times 1,8 = 1332\text{ төг/м}^3$ байна.

- 3700төг/м^3 - “Умард говийн гүвээт- Халхын дундад талын сав газар”-т газрын доорх
ус ашигласан нөхцөлд тооцох экологи, эдийн засгийн суурь үнэлгээ
- 20хувь -Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц
ашигласны төлбөрийн 4-д заасан хувь хэмжээ.
- 0.25- Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолын дагуу авто зам, засварт газрын
доорхи усыг ашиглахад тооцох ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр

$24480,0\text{м}^3 \times 185\text{ төг/м}^3 = 4528800,0\text{ төг}$ /дөрвөн сая таван зуун хорин найман мянга найман
зуун төгрөг/

Монгол улсын Засгийн газрын 2013 оны 326, 327 дугаар тогтоолыг үндэслэн ус ашигласны
төлбөрийг тооцвол:

- “Умард говийн гүвээт- Халхын дундад талын сав газар”-т газрын доорх ус
ашигласан нөхцөлд тооцох экологи-эдийн засгийн суурь үнэлгээ 3700 төг/м^3 байна.

- 15 хувь -Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 10-д заасан хувь хэмжээ,
- 0.25- ашиглах усны ашиглалтын зориулалтын итгэлцүүр
- 1728.0м³ жилд – ногоон байгууламжийн усалгаа
 $1728.0\text{м}^3 \times 74.0\text{төг} = 127872.0\text{төг}$ /нэг зуун хорин долоон мянга найман зуун далан хоёр төгрөг/
1м³ усны нөөц ашигласны төлбөр: $3700\text{төг}/\text{м}^3 \times 0.20 \times 1.5 = 88.8\text{төг}/\text{м}^3$ байна.
- "Умард говийн гүвээт- Халхын дундад талын сав газар"-т газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох экологи-эдийн засгийн суурь үнэлгээ 3700 төг/м³ байна.
- 15 хувь -Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 7а-д заасан хувь хэмжээ.
- 0.16- Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолын дагуу ашиг олох зориулалтаар ашиглах газрын доорхи усыг ашиглахад тооцох ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр
 $198.3\text{м}^3/\text{жил} \times 88.8\text{төг}/\text{м}^3 = 17609.0\text{төг}$ /хоёр мянга зургаан зуун жаран дөрвөн төгрөг/
Нийт төлбөр: $4528800.0 + 127872.0 + 17609.0 = 4674281.0\text{төг}$ ✓
/дөрвөн сая зургаан зуун далан дөрвөн мянга хоёр зуун наян нэгэн төгрөг/

17. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх, эргүүлж ашиглах даалгавар:


18. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөмж:

- Ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн Айраг сумын Засаг даргын захирамжаар ус ашиглах зөвшөөрөл авч гэрээ байгуулах /"Усны тухай" хуулийн 28.6-р зүйл/
- Усны шинжилгээг хийлгэж дүнг ирүүлэх
- "Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэм"-ийг мордон ажиллах /Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 хамтарсан тушаал/
- "Аж ахуйн нэгжийн экологийн паспорт" хөтлөх /Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйл, Стандартчилал хэмжилзүйн хэлтэсээс авах/
- Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг 50 хүртэл хувиар өсгөн тооцож төлөхөөр заасныг анхаарч ажиллах /Усны тухай хуулийн 31.2-р зүйл/
- Ус ашиглах зөвшөөрлийн хураамжийг Айраг сумын Төрийн сан банкны 060100995 дансанд тушааж хуулбар хувийг ирүүлэх /Монгол Улсын "Улсын тэмдэгтийн хураамжын тухай" хуулийн 21.1, 20-р зүйл, Дорноговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2011 оны 51-р тогтоол/
- Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс болох 50 000 төгрөгийг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Төрийн сан банкны 100 060013001 дансанд тушаах /Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А-376 тоот тушаал/
- Зөвлөмжид заасан ажлын тайлан, Ус ашиглалтын мэдээ тайланг 11 дүгээр сарын 05-нд багтаан аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлэх

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:



Ш. АМГАЛАНСАЙХАН

С. ЭНХЗОРИГ



2024 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 01/100

Цагаандөрвөлж

Ус ашиглах зөвшөөрөл олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх заалт, 66 дүгээр зүйлийн 66.1 дэх заалт, Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.11, 28.18, 30.1.1, 30.1.4 дэх заалтууд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны А/301 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын " Ус ашиглуулах тухай" 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 21 дугаартай дүгнэлтээр "Хонгор Овоо" нэртэй талбайд ашигт малтмал ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг "Мин Ли Да" ХХК-нд 24480.0 м³ усыг унд, ахуй болон үйлдвэрлэл, үйлчилгээний хэрэгцээнд 1 жилийн хугацаагаар ус ашиглуулах зөвшөөрөл олгосугай.

2. Ус ашиглах эрхийн бичиг авч төлбөрийг хугацаанд нь барагдуулан, усны эрүүл ахуйн бүс тогтоон хамгаалж, тоолууржуулах, усны чанарын шинжилгээ хийлгэн тайлан мэдээг ирүүлж усны дүгнэлт, гэрээнд заасан үүргийг хэрэгжүүлж хуулийн дагуу ажиллахыг "Мин Ли Да" ХХК-ийн захирал (Yang Zhenchun)-д, усны төлбөрийг ногдуулж, төлөлтөд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны бодлогын мэргэжилтэн (Г.Батмайхант)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Б.Амгаланбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.ЖАРГАЛСАЙХАН

4424810325

Батлав:
Айраг сумын Засаг дарга
...
С.Жаргалсайхан
2024 оны 6 сарын 20-ний өдөр

Батлав:
Мин Ли Да ХХК-ийн захирал
...
Чин Вен Лунг
2024 оны 6 сарын 20-ний өдөр

УС АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ

Айраг сум

Нэг: Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.11 дахь заалт, Байгаль орчин Ногоон хөгжил, Аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 сарын 30-ны өдрийн А/301 тоот тушаал, Дорноговь аймгийн Байгаль орчин, Аялал жуулчлалын газрын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн “Ус ашиглуулах тухай” 21 дүгээр дүгнэлтийг тус тус үндэслэн нэг талаас Айраг сумын ЗДТГ-ын байгаль орчны мэргэжилтэн Г.Батмайханта, нөгөө талаас уст цэгийг ашиглах “Мин Ли Да” ХХК-ийн гүйцэтгэх захирал Чин Вен Лунг нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Хоёр.Гэрээний зорилго

Ус ашиглагч “Хонгор овоо” нэртэй 9019088009 улсын бүртгэлийн дугаартай, 6302513 тоот регистрийн дугаартай, MV-005692 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Мин Ли Да” ХХК, ус ашиглуулагч Айраг сумын ЗДТГ болон тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Гурав.Гэрээний нөхцөл

- Ус ашиглах зориулалт :
 - Хайлуур жоншны орд ил аргаар ашиглах
- Ашиглах усны норм, хэмжээ:
 - Унд ахуйд 261,9 м³ /жил
 - Ногоон байгууламжийн усалгаа 108,0 м³
 - Зам талбайн тоосжилт дарахад 19980,0м³

Нийт: 20349,9м³ жилд ашиглана.

-216м³ жилд-ногоон байгууламжийн усалгаа
108,0 м³ x 92,5=9990,0 төг /*ерэн есөн мянга есөн зуун ерэн төгрөг*/

-19980,0 м³ жилд- зам талбайн тоосжилт дарах
19980,0 м³ x 185,0 = 3696300,0 төг / *гурван сая зургаан зуун ерэн зургаан мянга гурван зуун төгрөг*/

261 м³ жилд x 88,8 төг/м³ = 23256,7 төг / *хорин гурван мянга хоёр зуун тавин зургаан төгрөг долоон мөнгө*/

Нийт 9990,0 + 3696300,0 + 23256,7 = 3729546,7төг /*гурван сая долоон зуун хорин есөн мянга таван зуун дөчин зургаан төгрөг долоон мөнгө*/
- Ус ашиглах гэрээний хугацаа
2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс
2024 оны 12 дугаар сарын 20-ний өдөр хүртэл
- Усны эх үүсвэрийн байршил, барилга, байгууламж, тоног төхөөрөмж, тэдгээрийн хүчин чадал, төсөвт өртөг, тоо хэмжээ.
 - Ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэглээний усыг – Сумын төвийн худгаас тоолуурын заалт болон бодит хэрэглээгээр төлүүлнэ.

Дөрөв: Багийн Засаг дарга (уст цэг ашиглуулагч)-ын хүлээх үүрэг

- Уст цэг эзэмшигчийн уст цэг ашиглалт, хамгаалалтанд байнгын хяналт тавьж, гарсан зөрчил дутагдлыг тухай бүрт арилгуулах арга хэмжээ авна.
- Уст цэг эзэмшигчийн хариуцлагагүйгээс худгийн тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх, тоногдсон тохиолдолд бүрэн төлүүлэх арга хэмжээ авна
- Уст цэг эзэмшигчийн гэрээний биелэлтийг сар бүр дүгнэх
- Гэрээний биелэлтийг хангаж ажиллахыг шаардах, гэрээний хэрэгжилтийг дүгнэх эрхийг эдлэнэ

Тав: Уст цэг ашиглагчийн хүлээх үүрэг

- Уст цэг ажиллуулах цагийн хуваарь гарган багийн Засаг даргаар батлуулж мөрдөж ажиллана
- Ашиглалтын талбайд байрлаж буй малчдын зөвшөөрлийг авч, ус ашиглана
- Уст цэгийн барилга байшингийн засварын ажил, өнгө үзэмжтэй байлгах асуудлыг бүрэн хариуцна
- Уст цэгийн орчин тойрны 100 метр тутмын хог хаягдлыг өдөр бүр цэвэрлэнэ.
- Гэрээний хугацаа дуусгавар болмогц багийн Засаг даргад танилцуулах
- Дорноговь аймгийн БОАЖГ-ын 2024 оны 05 дугаар сарын 22 өдрийн 22 дугаар дүгнэлтээр тогтоосон төлбөрийг төлж барагдуулна

Зургаа: Гэрээ цуцлах

- Гэрээнд тусгагдсан Ус ашиглагчийн хүлээх үүргийг биелүүлээгүй тохиолдолд гэрээг дуусгавар болно.

Долоо: Талуудын хүлээх үүрэг хариуцлага

- Уст цэг ашиглагч нь гэрээний зүйл заалтыг удаа дараа зөрчсөн тохиолдолд гэрээг хүчингүй болгох шууд үндэслэл болж гарсан хохирлыг нөхөн төлүүлнэ.
- Талуудын хооронд үүссэн маргаантай асуудлыг сумын Засаг дарга шийдвэрлэх бөгөөд шийдвэрлэж эс чадвал хуулийн байгууллагаар шийдвэрүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

ЗДТГ-ЫН Байгаль орчны
бодлого хариуцсан
..... (Г.Батмайхант)

УТАС: 88101941

Ус ашиглагчийг төлөөлж:

“МИН ЛИ ДА” ХХК-Г ТӨЛӨӨЛЖ
Байгаль орчны мэргэжилтэн
..... Б.Бямбасүрэн

Утас: 88101993

**“СИ ЭМ КИНГС” ХХК-ийн MV-005692 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛТЭЙ “ХОНГОРЫН ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД”-ЫН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2024 он

Усны төлбөр төлсөн баримт

Trade and Development Bank of Mongolia		Date: 2024.06.18 11:00:38	
Transaction confirmation			
Journal №: 169359723			
Transaction date: 2024.06.18			
Name: CM KINGS FILLC			
From	Account No: 432078753	Name CM KINGS FILLC	Amount 4,674,281.00 MNT
			Rate 1.00
/ four million six hundred seventy four thousand two hundred eighty one tugrug /			
To	Bank No: 040000	Bank name Trade and Development Bank of Mongolia	Amount 4,674,281.00 MNT
	Account No	Name	Rate 1.00
Description: EB -3240601617201-Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр-Д			
Thank you			

Transaction statement verified

Branch, sub-branch:

Signature:

Stamp:

Date: ____ Year ____ Month ____ Day

Усны дүгнэлт зөвшөөрөл гэрээ байгуулахаар ажиллахад гарсан шатахууны 304367 төгрөгийн зардал бүхий баримтыг харуулав.



Хаягдал ус хаях дүгнэлт, завшөөрөл, гэрээ байгуулсаныг баримтаар харуулав.

УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ-ХАЛХЫН ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА ХАЯГДАЛ УСНЫ ДҮГНЭЛТ		
2024 оны 07 дугаар сарын 18-ны өдөр	Дугаар: 23	Говьсүмбэр Сүмбэр
1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, цахим хаяг: “МИН ЛИ ДА” ХХК, захирал Че Ван Ченг, Дорноговь аймаг, Айраг сум, 4-р баг, Цагаан дөрвөлж “ЗЦБЭ” ХХК-ийн байр. Улсын бүртгэлийн дугаар: 9019088009, регистрийн дугаар: 6302513. Утас: 9664-3116, 8810-1993		
2. Төслийн нэр, байршил: Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших “Хонгор овоо” нэртэй талбайд хайлуур жоншны ордыг ашиглах төсөл нь Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаанд хамаарна.		
3. Хаягдал ус хаях цэгийн байршил, координат: -		
4. Цэвэрлэгээний арга, түвшин: Ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг 10тн багтаамжтай ёмкост хуримтлуулж соруулах байдлаар шийдвэрлэсэн.		
5. Хаягдал усны хэмжээ: Тус компанийн хаягдал усны хэмжээг Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн №21 дугаартай ус ашиглуулах дүгнэлтээр гаргасан унд, ахуйн хэрэглээнд ашиглах $198.3 \text{ м}^3/\text{жил}$ -ийг тус тус үндэслэн тооцов.		
6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ, төрөл: Хаягдал усны шинжилгээ хийлгүүлээгүй тул Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын хамтарсан 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээг тогтоох тухай” А/816/218 тушаалаар батлагдсан хэмжээг үндэслэн ахуйд ажилчдын тосгон $1.5 \text{ кг}/\text{м}^3$ -ээр тооцов.		
7. Ус бохирдуулсны төлбөр, тооцоо: Органик бодис $/\text{XXX}/ 1.5 \text{ кг}/\text{м}^3 \times 198.3 \text{ м}^3/\text{жил} \times 50 \text{ төг}/\text{кг} = 14'872.50 \text{ төг}$ НИЙТ: 14'872.50 /Арван дөрвөн мянга найман зуун далан хоёр төгрөг тавин мөнгө/		
8. Хууль тогтоомж, дүрэм, журам, норм стандартын талаар зөвлөмж: - Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2013 оны А/156 дугаар тушаалаар баталсан “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-ын 2.1.4, 3.6.1 дэх заалтын дагуу хаягдал усны шугам дээр тоолуур суурилуулах - Байгаль орчин аялал жуулчлалын Сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2018 оны А-28/128 дугаартай “Ус ашиглагч иргэн, аж ахуй нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам”-ыг хэрэгжилтийг хангаж ажиллах, тайлан мэдээг Сав газрын захиргаанд ирүүлэх; - “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015” стандартаас давсан бол “Усны тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, БОАЖ-ын Сайдын 2019		

оны А/635 дугаар тушаалаар баталсан “Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам”-ын дагуу нөхөн төлбөр ногдуулахыг анхаарах;

9. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ:

- “Усны тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.13 дахь заалтад заасны дагуу Дорноговь аймгийн Айраг сумын Засаг даргатай байгуулсан “Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ”-г дүгнүүлж, сунгуулах

- “Усны тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтад заасны дагуу Дорноговь аймгийн Айраг сумаас олгосон “Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичиг”-ийг сунгуулах;

- Хаягдал усны дүгнэлтийг дараа оны эхний улиралд багтаан гаргуулах бөгөөд улирал бүр хоёроос доошгүй хаягдал усны сорьц авч, итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн, сүүлийн сарын 15-ны дотор ирүүлэх;

- Хаягдал ус хаях цэгийн байршлыг тогтоолгож Дорноговь аймгийн Айраг сумын ЗДТГ-аас зөвшөөрөл авах;

- Ус бохирдуулсны төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлөх ба хугацаанд нь төлөөгүй тохиолдолд “Зөрчлийн тухай” хуулиар хариуцлага хүлээх нөхцөл үүсэхийг анхаарах;

- Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д заасны дагуу усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус бохирдуулсны төлбөрийн гэрээг дүгнэсэн акт, хаягдал усны шинжилгээний дүгнэлтүүд, төлбөр төлсөн баримтыг Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны Umarhgobi14@gmail.com цахим хаягаар 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ХЯНАСАН:

УТГ - ХДТSGЗАХИРГААНЫ ДАРГА

Б. ОТГОНСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:

УТГ - ХДТSGЗАХИРГААНЫ МЭРГЭЖИЛТЭН

Н. СОЛОНГО





2024 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 18/141

Цагаандорлогч

**Хаягдал усны зөвшөөрөл олгох
тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь :

1. Умард говийн гүвээт халхын дундад талын усны сав газрын захиргааны 2024 оны 07 дугаар сарын 18-ний өдрийн 209 дугаартай дүгнэлтийн дагуу “Хонгор Овоо” нэртэй талбайд ил аргаар жонш олборлох “Мин Ли Да” ХХК-ийн үйл ажиллагаа явуулах хугацаанд ахуйн хэрэглээнээс гарсан хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгосугай.

2. Хаягдал усны дүгнэлтийг үндэслэн “Мин Ли Да” ХХК-тай хаягдал усны гэрээ байгуулан холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны бодлогын мэргэжилтэн (Г.Батмайхант), Нарт багийн Засаг дарга (Б.Байгальсайхан) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Б.Амгаланбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.ЖАРГАЛСАЙХАН

**“СИ ЭМ КИНГС” ХХК-ийн MV-005692 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛТЭЙ “ХОНГОРЫН ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД”-ЫН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2024 он

БАТЛАВ
АЙРАГ СУМЫН ЗАСАГ ДАРГА
С. ЖАРГАЛСАЙХАН
2024 оны 9 сарын 27-ны өдөр

БАТЛАВ
МИН ЛИ ДА /ХХК-ийн
ЗАХИРАЛ
МЕ ВАН ЧЕНГ
2024 оны 09 сарын 28-ны өдөр

**ХАЯГДАЛ УСЫГ ШУУД НИЙЛҮҮЛЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭДТЭЙ
БАЙГУУЛАХ УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ГЭРЭЭ**

2024.09.27

Дугаар 05

Цагаандөрвөлж

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйл, 24.2 дахь хэсэгт заасны дагуу Умард говийн Гүвээт-Халхын талын Сав газрын захиргааны гаргасан 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 11 дугаартай хаягдал ус хаях, зайлуулах дүгнэлтийг үндэслэн нэг талаас ус ашиглуулагчийг төлөөлж Айраг сумын Засаг Даргын Тамгын Газрын Байгаль орчны мэргэжилтэн Г.Батмайхант нөгөө талаас Ус бохирдуулагчийг төлөөлж Айраг сум 4-р баг Цагаандөрвөлж “ЗЦБЗ” ХХК-ийн байр, 9019088009 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, 6302513 тоот регистрийн дугаартай хуулийн этгээдийг төлөөлж “Мин ли да” ХХК-ийг төлөөлж байгаль орчны ажилтан Б.Бямбасүрэн нар ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөр төлөх талаар харилцан тохиролцон энэхүү гэрээг 1 (нэг) жилийн хугацаатай байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усыг Хүрээлэн байгаа орчин.Усны чанар.Хаягдал ус.Ерөнхий шаардлага MNS 4943:2015 стандартын норматив шаардлагад нийцүүлэн байгальд шууд нийлүүлнэ.

2.2. Ус бохирдуулагч нь Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усны чанарыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлэн ус бохирдуулсны төлбөр, стандартын норматив шаардлагад нийцүүлээгүй тохиолдолд ус бохирдуулсны төлбөрийг хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын хэмжээнээс хамааран 2-5 дахин шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлнө.

2.3. Төлбөр төлөгч нь Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөр, нөхөн төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харъяалах татварын албанд төлнө.

Органик бодис /XXX/: $1,5 \text{ кг/м}^3 \times 198,3 \text{ м}^3/\text{жил} \times 50 \text{ төг/кг} = 14872,50 \text{ төг}$

Нийт дүн: 14872,50 төг /Арван дөрвөн мянга найман зуун далан хоёр төгрөг тавин төгрөг/

2.4. Ус бохирдуулагч нь дараах мэдээллийг улирал тутамд Сав газрын захиргаа, харъяа татварын албанд хүргүүлнэ. Үүнд:

2.4.1. Хаягдал ус нийлүүлдэг хүн, хуулийн этгээдийн нэр;

2.4.2. Цэвэрлэх байгууламж болон зөөврийн машинд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;

2.4.3. Байгальд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;

2.4.4. Хаягдал усанд байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн шинжилгээний дүн;

2.4.5. Бохирдуулах бодисын ялгарал шилжилтийн системд усны бохирдлын мэдээллийг бүртгүүлнэ;

2.4.6. Ус бохирдуулсаны төлбөр төлсөн тайлан;

Гурав. Ус ашиглуулагчийн эрх, үүрэг

3.1. Ус бохирдуулагчийг мэдээ, мэдээлэл, удирдлагаар хангаж, хяналт тавина.

3.2. Усны тухай хуулийн 17.1.8 дахь хэсэгт заасны дагуу Сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтад заасны дагуу Сум, дүүргийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ хаягдал ус зайлуулах цэг тогтооно.

3.3 Сав газрын захиргаа болон сум дүүргийн Засаг дарга нь хаягдал усыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлэн цэвэрлэсэн, дахин ашигласан ус бохирдуулагчийг ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх жагсаалтыг гаргана.

3.4. Сав газрын захиргаа, сум дүүргийн Засаг дарга нь хаягдал ус хаях, зайлуулах шаардлагыг зөрчсөн ус бохирдуулагчийн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг цуцална.

Дөрөв. Ус бохирдуулагчийн эрх, үүрэг

4.1. Ус бохирдуулагч нь Сав газрын захиргаанаас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авах, хаягдал ус хаях, зайлуулах цэг тогтоох, ногдуулсан ус бохирдуулсны төлбөр болон нөхөн төлбөрийн хэмжээг үндэслэлгүй гэж үзвэл дээд шатны байгууллагад гомдол гаргах эрхтэй.

4.2. Ус бохирдуулагч нь үйл ажиллагаандаа энэхүү гэрээг болон холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм норматив, ТЭЗҮ, зураг төсөл, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдөж ажиллана.

4.3. Ус бохирдуулагч нь хаягдал усны эзэлхүүнийг тодорхойлох хэмжих хэрэгсэл (тоолуур)-ийг “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-д заасны дагуу хаягдал усны шугамын гаргалгаан дээр суурилуулах тоолуур нь гаргалгааны шугамын голчтой адил байх бөгөөд мэдрэгчийн хийц нь хаягдал усны найрлагаас хамааран өөрчлөгдөх, эвдрэх, гэмтэх, зэрэг эрсдэлээс хамгаалагдсан эд ангиар хийгдсэн байх шаардлагад нийцүүлэн суурилуулна.

4.4. Ус бохирдуулагч нь хаягдал усны дүгнэлтэд тусгагдсан шаардлага, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, зөвлөмжийн дагуу сумын Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулж хамтран ажиллах

Тав. Бусад

5.1. Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

5.2. Ус бохирдуулагч нь ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.3. Энэхүү гэрээг сунгах, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой асуудлыг 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

5.4. Энэхүү гэрээтэй холбогдсон гарсан аливаа маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд эс тохиролцвол иргэний журмаар шүүхээр шийдвэрлүүлнэ.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйлс

6.1. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл (тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт гэх мэт)-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас (нөхөн төлбөр, торгууль) чөлөөлөгдөх болно.

6.2. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл бий болсныг нотолно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

Дорноговь аймгийн Айраг сумын
Засаг даргын Тамгын газрын Байгаль
орчны мэргэжилтэн
..... (Г.Батмайхант)

Хаяг: Монгол улс, Дорноговь аймаг,
Айраг сум, 4 дүгээр баг, Засаг Даргын
Тамгын Газар 1 дүгээр байр 106 тоот
Харилцах утас: 88101941

Ус ашиглагчийг төлөөлж:

"Минли да" ХХК-ийн төлөөлж байгаль
орчны мэргэжилтэн
..... Б.Бямбасүрэн

Хаяг: Айраг сум 4-р баг
Цагаандөрвөлж

Харилцах утас: 881019993

2024 OH

Хуучингийн нэвчлэл дугаар: 000300049		Төлбөр нэмнэ: 2024.11.01 10:47	
Нийслэлүүсгэлтийн эрхэмнэл дүгнэлт	Хуучин нийслэлтийн дүн	Гүйцэтгэлийн дүн	Гүйцэтгэлийн төлбөр
1115110949 00000000000000000000	1165117377	14,072.50 MNT	Амжилттай
Нийслэлүүсгэлтийн нэр MNN LN DA	Хуучин нийслэлтийн нэр TAX	Гүйцэтгэлийн үтгэ 1231101007207;30100229726;6302513;30100229 726;00115600	
	Хуучин нийслэлтийн байр	Гүйцэтгэлийн огноо 2024-11-01	

Хаягдал усны дүгнэлт гэрээтэй холбогдон гарсан шатахууны 250000 төгрөгийн зардалыг баримтаар харуулав.

[illegible][illegible]

2.2.2 100м зайд Хамгаалатын бүс тогтоох, худгийн барилгын дотор шал цементлэх цахилгааны эх үүсвэр тусгаарлаж тасалгаа хийх, тоолууржуулж, баталгаажуулах, Сумын БОХУБайцаагчаар усны тоолуурт хяналт хийлгэж акт үйлдэх төлөвлөгөө нь хэрэгжүүлэх шаардлагагүй болсон. Учир нь 2019 онд ашиглаж байсан гүний худаг ус гарахгүй болсон учир 2023 онд уртраг-109.02.50.29, өргөрөг-45.47.40 солбилцолд худаг гаргах зөвшөөрөл авч өрөмдлөг хийлгэж худаг гаргасан боловч мөн адил ус гарахгүй байгаа учир худаг ашиглах боломжгүй байна. Иймээс Айраг сум дахь “Чандмань илч” ХХК-тай гэрээ байгуулж ус зөөвөрлөн ашигласан болно.

Зураг 3. Шинэ ба хуучин Худаг



“СИ ЭМ КИНГС” ХХК-ийн MV-005692 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛТЭЙ “ХОНГОРЫН ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД”-ЫН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

2024 он



ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ, ЦЭВЭР УСААР ХАНГАХ,
БОХИР УС ТАТАН ЗАЙЛУУЛАХ ГЭРЭЭ

2024 он 02 сар 02 өдөр

дугаар Аж ахуйн нэгж

Сайншанд

Энэхүү гэрээг нэг талаас “Чандмань-Илч” ХХК-ийг төлөөлж Ерөнхий инженер ажилтай Б.Бат, Айраг салбарын дарга Ш.Шинэбилэг /цаашид хангагч гэх/, нөгөө талаас С.Э.М.Кингс регистрийн дугаар 60002-2-302494 ажилтай С.Б.Б.Н. овогтой М.Э.Н. Бат /цаашид хэрэглэгч гэх/ хамтад нь талууд гэх ба талууд харилцан тохиролцож Монгол улсын “Иргэний хууль” болон “Эрчим хүчний тухай хууль”, “Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм”, “Дулааны эрчим хүчийг хэмжих тооцох дүрэм”, “Дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч-хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм”, “Усны тухай хууль”, “Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль”, “Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм”, “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам болон бусад хууль эрх зүйн актуудыг үндэслэн доорх нөхцөлөөр энэхүү гэрээг 2024 оны 02 сарын 02 өдөр хүртэл байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.5. Энэхүү гэрээний зорилго нь хангагчаас хэрэглэгчрүү нийлүүлж буй дулааны эрчим хүч, цэвэр усаар хангах, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлэхэд үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.6. Энэхүү гэрээний хавсралтууд нь гэрээний салшгүй хэсэг болно. Үүнд:
 - 1.6.1. Хавсралт №1 Мөрдөгдөх үнэ тариф
 - 1.6.2. Хавсралт №2 Шугам сүлжээний эзэмшлийн зааг
- 1.7. Хэрэглэгч нь өөрсдийн эзэмшлийн дулааны шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалтыг бүрэн хариуцаж, үүсгэж үйлчилгээ засвар шинэчлэлтийг өөрийн хөрөнгөөр мэргэжлийн байгууллага болон хангагч талаар хийлгэнэ.
- 1.8. Гэрээнд 2 тал гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

Хоёр. Хангагчийн эрх, үүрэг

- 2.13. Эрчим хүчний тухай хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийн заалтыг хэрэгжүүлж хэрэглэгчийг гэрээнд заасан горимын дагуу дулааны эрчим хүч, цэвэр усаар хангаж, бохир усыг татан зайлуулах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.
- 2.14. Хэрэглэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэлгүй инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжид гэмтэл гургасан, системд хохирол учруулсан болон хортой бодистой бохир ус нийлүүлсэн тохиолдолд холбогдох хууль журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэж, хангагчид учруулсан эд материалын хохирол барагдуулахыг шаардах эрхтэй.
- 2.15. Инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ээлжит их болон урсгал засвар, туршилт тохируулгыг хугацаанд нь чанартай хийж найдвартай ажиллагааг хангана. Тоног төхөөрөмж, шугам сүлжээг засварт оруулахтай холбогдон ус, дулааны эрчим хүчийг түр таслахаар бол энэ тухай хэрэглэгчид урьдчилан мэдэгдэж ажлаа зохицуулах боломж олгоно.
- 2.16. Хэрэглэгчийн дулааны төв болон зангилааны зарцуулалтыг тохируулах хэрэгсэл / шайба /-ийг тооцож бэлтгэн тавьж битүүмжлэх.
- 2.17. Хангагч, хэрэглэгчийн шугамд зохих зөвшөөрөл бүхий хэмжих хэрэгсэл, тоолуурыг график төлөвлөгөөний дагуу тавьж хөрөнгийн асуудлыг хэрэглэгчтэй тохирч шийдвэрлэнэ. Хангагч энэ үүргээ хэрэгжүүлэхэд хэрэглэгч саад учруулах эрхгүй.
- 2.18. Хангагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хэрэглэгчийн дулааны эрчим хүч, цэвэр усаар хангах, ариутгах татуургын технологийн үйлчилгээг “Эрчим хүчний тухай”, “Усны тухай хууль”, Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” хуулиуд болон гэрээнд заасны дагуу

- түдгэлзүүлж, зөрчлийг арилгахыг шаардана. Зөрчил арилсан тухай бүр хэрэглэгчийг үйлчилгээгээр саадгүй хангах бөгөөд хэрэглэгчийн буруугаас болж, таслах, залгахад гарсан зардлыг хангагч хариуцахгүй
- 2.19. Хангагч нь хэрэглэгчийн захиалгаар ажил гүйцэтгэхэд бусад хэрэглэгчийн ус, дулаан хангамжийг түр хугацаагаар түдгэлзүүлэх бол энэ тухай 24-аас доошгүй цагийн өмнө тухайн хэрэглэгчид урьдчилан мэдэгдэнэ.
- 2.20. Хангагчийн эрх бүхий ажилтан ажил үүргийн шаардлагаар хэрэглэгчийн өмчлөлийн объектод хэрэглэсэн дулаан, цэвэр, бохир усны бичилт хийж тоолуур, хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагааг шалгах, тооцоо нийлэхээр нэвтрэн орох эрхтэй.
- 2.21. Хэрэглэгчийн ус хангамж, ариутгах татуурга, дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээний ашиглалт, засварын байдал, аюулгүй ажиллагааны шаардлага, халаалт, хэрэгцээний халуун ус хангамжийн чанар зэрэгт өөрийн төлөөлөгчөөр хяналт тавиулж, илэрсэн зөрчлийг арилгуулах эрхтэй.
- 2.22. Хангагч нь ус, дулааны эх үүсвэр болон тоног төхөөрөмж, инженерийн шугам сүлжээнд гарсан ноцтой гэмтэл саатлыг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх хойшлуулшгүй арга хэмжээ авах шаардлагатай нөхцөлд ус, дулаан хангамжийг шууд зогсоох эрхтэй бөгөөд зогсоосон шалтгаанаа хэрэглэгчид нэн даруй мэдэгдэнэ.
- 2.23. Ус дулаан хангамжийг дор дурдсан нөхцөлд хэрэглэгчид мэдэгдсэний дараа зогсооно. Үүнд:
- а/ Хангагч төлөөлөгчөөр засвар хийх үед
 - б/ Хэрэглэгч зөвшөөрөлгүй холболт хийсэн үед
 - в/ Хэрэглэгч цэвэр ус, ариутгах татуурга, дулаан хэрэглэсний төлбөрийг заасан хугацаанд төлөөгүй
 - г/ Ус, дулааны тоолуурыг улсын баталгаагүй ашигласан буюу эвэлтийг бүртгүүлээгүй
- Дулааны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй буюу удаан хугацаагаар барагдуулаагүйн улмаас хэрэглээг тасалсан тохиолдолд учирсан хохиролыг хэрэглэгч өөрөө бүрэн хариуцна.
- 2.24. Дор дурдсан нөхцөлд бохир ус татан зайлуулахыг зогсооно. Үүнд:
- а/ Бохир усны хортой, цацраг идэвхт болон дэлбэрэх шатах чанартай бодис агуулсан
 - б/ Бохир ус нь +30°C-аас өндөр хэмтэй
 - в/ Бохир ус нь хурц буюу халдварт өвчний нянгаар бохирлогдсон
 - г/ Ахуйн бохир усны үзүүлэлтүүдийн түвшинд хүртэл урьдчилан цэвэрлээгүй үйлдвэрийн бохир ус буюу хүнд металлын бохирдлыг ихээр агуулсан
 - д/ Нефть, нефтийн бүтээгдэхүүн агуулсан

Гурав. Хэрэглэгчийн эрх, үүрэг

Өөрийн эзэмшилд байгаа инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай ажиллагааг хангахтай холбогдсон дараах эрх, үүргийг хэрэглэгч хүлээнэ. Үүнд:

- 3.1. Хэрэглэгч стандартын шаардлага хангаагүй дулаан, цэвэр ус нийлүүлсэн тухай бүр хангагчид мэдэгдэж хэвийн болгохыг шаардах эрхтэй.
- 3.2. Хэрэглэгч нь ус, дулааны хэрэглээнд дотоодын хяналт тавих зорилгоор шаардлагатай нэгж, хэсэг, тоног төхөөрөмжид хяналтын хэмжүүр тавьж шалгах эрхтэй. /Шалгах талаар хангагчид мэдэгдэнэ/
